

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025
ГАРААНЫ ҮНЭЛГЭЭ **МОНГОЛЫН ТҮҮХ** **Хувилбар С**
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

- а. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
б. Сонгох даалгавараас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Мезолитийн үед хамаарах он цагийг олно уу /1 оноо/
A. 12000–8.000 жил B. 100.000–40.000 жил C. 40.000–12.000 жил
D. 800.000–12.000 жил E. 800.000–НТӨ 3.000 жил
2. Монгол нутаг дахь хамгийн эртний хадны зураг аль үед холбогдох вэ? /1 оноо/
A. Неолит B. Мезолит C. Дээд палеолит
D. Доод палеолит E. Дунд палеолит
3. “Дээд палеолитын үеэс хүн ам өсөж, идэшний ургамал ховордсон, мөстлөгийн нөлөөгөөр том ан амьтад цөөрсөн” гэсэн нь юу үүсэх нөхцөл вэ? /1 оноо/
A. Нүүдлийн иргэншил үүсэх нөхцөл B. Олзворлох аж ахуй эрчимжих нөхцөл
C. Ан гөрөө, загасчлах аж ахуй үүсэх нөхцөл D. Түүвэрлэх аж ахуй үүсэх нөхцөл
E. Үйлдвэрлэх аж ахуй үүсэх нөхцөл
4. Нүүдэлчдийн түүх, соёлын дурсгал болох буган чулуу нь түүхийн аль үед холбогдох вэ? /1 оноо/
A. Неолитын үе, энеолитын эхэн үе B. Мезолитын үе, неолитын эхэн үе
C. Палеолитын дээд шат D. Хүрлийн үе, төмрийн түрүү үе
E. Энеолит буюу зэс чулууны үе
5. Нүүдлийн мал аж ахуй бие даан хөгжихтэй зэрэгцэн хөдөлмөрийн багаж зэвсгийн хөгжилд ямар дэвшил гарсан бэ? /1 оноо /
A. Малын арьс, шир, үс ноос боловсруулах B. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл
C. Ваар, шаазан урлал D. Нум сумыг хийх арга, технологи
E. Сүү, цагаан идээ боловсруулах арга
6. Нүүдлийн иргэншилд аль нь чухал үүрэгтэй байсан бэ? /2 оноо/
A. Нум сумыг хийх арга, технологи B. Хүрэл, зэс зэвсгийн үйлдвэрлэл
C. Ваар сав, шаазан эдлэлийн үйлдвэрлэл D. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл
E. Сүү, цагаан идээ боловсруулах арга
7. Ноён уулын Хүннүгийн язгууртны булшнаас буга, хээ угалзыг өнгө алаглуулсан ширмэл эсгий ширдэг олдсон нь юуг илэрхийлэх вэ? /1 оноо/
A. Хүннү нар хээ угалзыг хэрэглэх нь түгээмэл байсан
B. Хүннү нарт малын үс, ноос боловсруулах технологи өндөр хөгжсөн
C. Хүннүгийн жирийн иргэд ширмэл эсгий ширдэг хэрэглэж байсан
D. Хүннү нар ширмэл эсгий ширдэг хэрэглэх нь түгээмэл байжээ
E. Хүннү нарын бэлгэдэл нь буга болон бусад амьтад байсан
8. Неолитын үед болхидуу, зээтүүт газар тариалан үүссэнийг гэрчлэх олдвор аль нь вэ? /2 оноо/
A. Ховд аймгийн Хойд цэнхэрийн агуйн хадны зургийн дүрслэл
B. Баянхонгор аймгийн Баянлигийн цагаан агуйн бууц
C. Увс аймгийн Сагил сумын Можоогийн хадны зургийн дүрслэл
D. Баянхонгор аймгийн Нарийн голын суурингийн хөдөлмөрийн багаж зэвсгүүд
E. Өмнөговь аймгийн Баянзагаас олдсон чулуун самбар, нухуур
9. Жужан улс мөхсөн гол шалтгаан нь юу вэ? /1 оноо/

- A. Тоба Вэй улсын довтлогоо B. Хаан ширээний төлөөх тэмцэл
C. Олон жил үргэлжилсэн ган зуд D. Алтайн Түрэгүүдийн бослого
E. Жужанчууд суурин соёлд автсанаас
10. 840 онд Уйгар улс Енисейн Киргизүүдийн довтлогоонд өртөн мөхөв. Уг оныг зууны тоололд шилжүүлнэ үү /2 оноо/
A. НТ IX зууны I хагас B. НТӨ IX зууны I хагас C. НТӨ VIII зууны I хагас
D. НТ VIII зууны II хагас E. НТӨ IX зууны II хагас
11. Сяньбигийн нэг салбар Шар мөрөн, Ляоси орчмоор нутагласан ба тэднийг IV зууны сүүлээр Хятан хэмээн нэрлэх болжээ. Энэ баримт ямар утга санаа илэрхийлж байна вэ? /2 оноо/
A. Хятаны өвөг дээдэс Ляоси орчимд нутаглаж байсныг баталдаг
B. Хятанчууд анх Сяньби хэмээн нэрлэгдэж байсныг нотолдог
C. Хятаны өвөг дээдэс Шар мөрөнд орчимд нутаглаж байсныг баталдаг
D. Хятанчууд өмнө зүгт нутаглаж байсныг нотолдог
E. Сяньби ба Хятан улсууд угсаа гарвал нэг болохыг нотолдог
12. Хятан гүрэнд олон шашин дэлгэрч байсан ч Хятаны хаад аль шашныг тэтгэх болсон бэ? /1 оноо/
A. Бурхны B. Бөөгийн C. Манихейн D. Христийн Несторын E. Лалын
13. Эртний улсуудын түүхэнд холбогдох археологийн олдвор олдсон газар, олдворуудыг улстай нь зөв харгалзуулна уу? /2 оноо/
1. Хүннү a. Ховд аймаг Эрдэнэбүрэн сум Цамбагарав уулын хуягт морин цэргийн хадны зураг
2. Жужан b. Архангай аймаг Хашаат сум Култегин жанжны хөшөө
3. Түрэг c. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Дуурлиг нарсны булш нар саран хэлбэрт алтан ялтсан чимэг
A. 1b2c3a B. 1a2c3b C. 1a2b3c D. 1c2a3b E. 1b2a3c
14. XI-XII зууны Монгол аймгуудаас аль нь Байгаль нуур, Баргужин төхөм, Горлог мөрний ай сав газраар нутаглаж байсан бэ? /1 оноо/
A. Тайчууд B. Онгуд C. Ойн иргэд D. Найман E. Мэргид
15. Монгол аймгууд аж ахуйн хувьд талын малчин, ойн анчин хэмээх хоёр бүлэгт хуваагддаг. Талын малчин аймгууд ямар хавсрага аж ахуй эрхэлдэг вэ? /1 оноо/
A. Цаа буга, аргаль, сарлаг гаршуулан, сүү шимийг нь хүртэх
B. Ан гөрөө, газар тариалан эрхэлж ашиг шимийг нь хүртэх
C. Үслэг эдлэл, үнэт чулууны худалдаа эрхлэх
D. Загас агнуур болон шаазан, ваар урлал эрхлэх
E. Эсгий ширэх, гар урлалын аж ахуй эрхлэх
16. 1 ба 2 жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? /2 оноо/
1. Боржигон, Тайчууд, Жадаран
2. Булгачин, Хэрэмчин, Ойрад, Урасуд
A. Оршин тогтносон цаг хугацаагаар B. Бөөгийн шашны зан үйлээр
C. Шашин шүтлэгийн хэлбэрээр D. Угсаа гарвал, газарзүйн байршлаар нь
E. Засаглалын хэлбэрээр
17. Чингис хаан эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлж олон жилийн “өшил өшин, хясал хясахаар” их цэргийн хүчээр аль улс руу довтолсон бэ? /1 оноо/
A. Хар Хятан улс B. Тангуд улс C. Сүн улс D. Хорезм улс E. Алтан улс
18. Ил хаант улсын нийслэлийг сонгоно уу /1 оноо/
A. Тебриз B. Аксу C. Дайду D. Бат сарай E. Алмалиг
19. Ил хаант улсын газар нутагт өнөөгийн аль улсууд хамаарах вэ? /2 оноо/
A. Казакстан, Монгол, Киргизстан B. Хятад, Солонгос, Брим

С. Иран, Ирак, Азарбайжан, Хятад
Е. Гүрж, Армен, Орос, Турк

Д. Иран, Ирак, Азербайжан, Турк

20. Дундад Азийн түүхч Абул Гази Бахадур “Монголын эзэнт гүрний тухайд” хэлэхдээ: “Иран, Тураны хоорондох бүх улс оронд урьд байгаагүй энх амгалан үе ирэв. Толгой дээрээ сагс алт тавиад дорноос өрнө тийш цор ганцаар аялан явах бүрэн боломжтой ажгуу” хэмээжээ. Уг сурвалжийн гол утгыг оновчтой тодорхойлсоныг олно уу /2 оноо/

- А. Иран болон Турины хооронд аялах, худалдаа арилжаа эрхлэхэд ихээхэн эрсдэлтэй байсан тухай
- В. Ази, Европ дагуу худалдаа арилжаа цэцэглэн хөгжиж байсан тухай
- С. Монголын эзэнт гүрний нэгдсэн захиргаанд орсоноор энх амгалан үе ирсэн тухай
- Д. Монголын эзэнт гүрэн дорноос өрнө тийш асар удам нутгийг эзлэн захирсан тухай
- Е. Дайн самуу, дээрэм тонуулгүй тайван, амгалан болсон тухай

21. XV зууны эхэн үеэс Монголын улс төрийн нэгдмэл байдал сулран, доройтож, зүүн, баруун Монгол хэмээн хуваагдан тэмцэлдэх болсны гадаад шалтгааныг олно уу? /1 оноо/

- А. Шарын шашин дэлгэрсэн үйл явдал болсон
- В. Мин улсын хагалган бутаргах бодлого явагдсан
- С. Эзлэгдсэн орнуудын бослого тэмцэл болсон
- Д. Мянгатын тогтолцоонд шилжсэн үйл явдал болсон
- Е. Ноёдын бие даах эрмэлзлэл ихэссэн

22. 1388-1400 оны хооронд Монголд таван хаан суусан нь бүгд цаг бусаар хорвоог орхисон байна. Дээрх үйл явдал нь ямар утга санааг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- А. Эзэн, харьяатын харилцааны зөрчил
- В. Шарын шашин дэлгэрсний сөрөг нөлөөлөл
- С. Хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч гарахгүй байсан
- Д. Улс төрийн хямрал гүнзгийрсэн
- Е. Эзлэгдсэн орнуудын бослого тэмцэл

23. Мин улстай найрамдлын гэрээ байгуулж, Урианхан түмнийг 6 удаа довтлон, Хөх нуур, Ойрадыг эрхэндээ оруулж, дотоодын зөрчлийг намжаасан түүхэн зүтгэлтнийг сонгоно уу /1 оноо/

- А. Лигдэн хаан
- В. Эсэн тайш
- С. Батмөнх даян хаан
- Д. Түмэн засагт хаан
- Е. Түмэдийн Алтан хан

24. Төвөд, Хөх нуурыг эзэлсний үр дүнд Хошууд улсыг хэн байгуулсан бэ? /1 оноо/

- А. Төрбайх Гүүш хан
- В. Цоросын Эрдэнэбаатар хунтайж
- С. Халхын Цогт тайж
- Д. Цахарын Лигдэн хаан
- Е. Ойрадын Галдан бошигт хаан

25. 1368 онд Тогоонтөмөр хаан эх нутагтаа буцаж, Дайду хот аль улсад эзлэгдсэн бэ? /1 оноо/

- А. Дундад Иргэн улс
- В. Манж Чин улс
- С. Хятад улс
- Д. Мин улс
- Е. Чусон улс

26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн дотоод хүчин зүйлийг олно уу /2 оноо/

- А. Бурхны шашны шар, улааны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхээр өрсөлдөж байсан
- В. Төвөд улс шашны урсгалууд хоорондын мөргөлдөөний улмаас доройтож гаднаас эдийн засгийн дэмжлэг хайж байсан
- С. Эрх баригчид Монголчуудыг оюун санааны хувьд нэгтгэх зорилгоор шашныг ашиглаж байсан
- Д. Мин улсын түрэмгийллээс өөрсдийгөө хамгаалахын тулд Монголын цэрэг, эдийн засгийн тусламж нэн чухал байсан
- Е. Монголын мал сүрэг, идээ шүүс нь Төвөдийн шар, улааны урсгалуудад томоохон дэмжлэг болж чадсан

27. Дараах шашин, соёлын зүтгэлтнүүдээс хэн Эрдэнэ зуу хийдийг байгуулсан бэ? /1 оноо/

- А. Манзушир хутагт
- В. Автай сайн хан
- С. Нэйж Тойн
- Д. Зая бандида Лувсанпэрэнлэй
- Е. Түмэдийн Алтан хан

28. Бурхны шашин нэвтрэхээс өмнөх үеийн Монгол соёлын баримт аль вэ? /2 оноо/
 А. Соёмбо, Тод, Али Гали үсгүүд зохиогдов
 В. Монголын дүрслэх урлагт цутгуурын урлаг гэдэг төрөл шинээр бий болов
 С. Энэтхэг, Төвөдийн ном судрыг Монгол хэлнээ хөрвүүлэх ажил эрчимтэй хөгжив
 D. Хаад, ноёд асар том гэр тэрэг хэрэглэж байв
 E. Ногоон дарь эх, хорин нэгэн дарь эх зэрэг бүтээлүүд бий болов
29. XVII зуунд Зүүнгараас Халимаг руу хэдэн удаа нүүдэл болсон бэ? /1 оноо/
 А. 5 удаа В. 6 удаа С. 1 удаа D. 4 удаа E. 8 удаа
30. 1727 оны Буурын гэрээний гол агуулга аль вэ? /1 оноо/
 А. Буриад Монголчууд Орос улсын мэдэлд бүрэн орсон
 В. Орос улс Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг харьяандаа оруулсан
 С. Байгаль нуурын баруун биед Эрхүү өвөлжөөг байгуулах тохиролцоо
 D. Байгаль нуурын зүүн талын Баргужин шивээг мэдэлдээ авах тохиролцоо
 E. Үд шивээг байгуулж, бэхжүүлэх шийдвэр тохиролцоо
31. 1688 оны “Халх – Зүүнгар”-ын дайн ямар үйл явдлаар эхэлсэн бэ? /1 оноо/
 А. Сэцэн хан, Засагт ханы хооронд хил хязгаарын маргаан бий болсноос
 В. Хүрэн бэлчирийн чуулганд Манж Чин улсын хаан ирж оролцсоноор
 С. Төвөдийн далай ламын төлөөлөгч Хүрэн бэлчирийн чуулганд хүрэлцэн ирсэнээр
 D. Түшээт ханы цэрэг Халхын баруун гарт довтлон Галданбошигтын дүү Доржжавыг хөнөөснөөр
 E. Засагт хан, Зүүн гарын хооронд хил хязгаарын маргаан бий болсноос
32. 1755-1758 оны Ойрад Монголд гарсан Манжийг эсэргүүцсэн бослогод тэмцлийн ямар хэлбэр зонхилж байсан бэ? /1 оноо/
 А. Манжийн албыг хаяж босох В. Өртөө харуулыг довтлон цохих
 С. Зэвсэгт бослого D. Дугуйлангийн хөдөлгөөн E. Сайн эрсийн тэмцэл
33. Өвөр Монголын хошуу тайж Цогдалайн удирдсан зэвсэгт бослого ямар үр дүнд хүрсэн бэ? /2 оноо/
 А. Манж нар Өвөр Монголын Малчидад бэлчээр нутгаа алдсан
 В. Манж нар Жалайд хошуунд газар хагалбарлахаа түр зогсоосон
 С. Манж нар Өвөр Монголд Хятад тариачидыг олноор нь оруулах болсон
 D. Манж нар их хэмжээний шан харамж амлаж бослогыг зогсоосон
 E. Манж нар өндөр албан тушаал амлаж бослогыг түр зогсоосон
34. Манжийн эрхшээлийн үеийн Халхын дөрвөн аймаг, Ховдын хязгаарыг газарзүйн байршлаар нь зүүнээс баруун руу зөв эрэмбэлнэ үү /1 оноо/
 1. Түшээт хан аймаг 2. Засагт хан аймаг 3. Сэцэн хан аймаг
 А. 1,2,3 В. 2,1,3 С. 1,3,2 D. 3,1,2 E. 2,3,1
35. “Шинэ засгийн бодлого”-ыг хэрэгжүүлэх шийдвэр хэзээ гарсан бэ? /1 оноо/
 А. 1801 он В. 1911 он С. 1758 он D. 1691 он E. 1901 он
36. Манжийн төрөөс Монголд хэрэгжүүлсэн “Шинэ засгийн бодлого”-ын эдийн засгийн хүрээнд үзүүлэх үр дагаврыг Монголчууд юу гэж үзэж байв? /2 оноо/
 А. Малын бэлчээрийг тариалангийн талбай болгох бодлого В.
 Монголыг Хятадчилах бодлого С.
 Хэл соёл, шашныг устгах бодлого
 D. Хятад биш үндэстнийг хүчээр Хятадад уусган устгах
 E. Хятадтай адил болгох бодлого
37. 1911 оны хувьсгалын үр дүнд аль улсын эрхшээлээс гарсан бэ? /1 оноо/
 А. Манж Го улс В. Хятад улс С. Дундад иргэн улс
 D. Манж Чин гүрэн E. Бүгд найрамдах Хятад ард улс

38. “1911 оны 12-р сарын 29-ний өдрийг яг ёслол болсон цаг мөчид, Монголын өнцөг булан бүрт хүмүүс хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясчээ.” Дээрх түүхэн үйл явдал бидэнд юуг ойлгуулж байна вэ? /2 оноо/
- A. Өвөг дээдсээ хүндэтгэх ёсыг бэхжүүлэх үйл хэрэг
 - B. Ёс заншил, өв уламжлалаа хүндэтгэх үзэл санааг
 - C. Эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэн
 - D. Шашин шүтлэг, өв соёлоо хүндэтгэх үйл явдал
 - E. Бэлгэдэл хүндэтгэлийн зан үйлийг илэрхийлсэн
39. С.Данзангийн байгуулсан улс төрийн бүлгэмийг сонгоно уу /1 оноо/
- A. Консулын дэнжийн бүлгэм
 - B. Зүүн хүрээний бүлгэм
 - C. Угсаатан хэргэмтний бүлгэм
 - D. Ноёдын бүлгэм
 - E. Ногоонтны бүлгэм
40. 1921 оны 7-р сарын 10-нд засгийн эрх шилжүүлэх ёслолоор аль засгийн газар байгуулагдсан бэ? /1 оноо/
- A. Монгол улсын засгийн газар
 - B. Ардын түр засгийн газар
 - C. Богд хааны засгийн газар
 - D. Ардын засгийн газар
 - E. Анхны засгийн газар
41. 1921 оны Ардын түр засгийн газрын нэн тэргүүний зорилтыг олно уу /2 оноо/
- A. Улаан цэргийн аялан байлдах корпусыг нэн даруй оруулах
 - B. 1921 оны хувьсгалын үйл ажиллагааг зохион байгуулах
 - C. Хятадын цэргийг Монголоос хөөн гаргах, нийслэл хүрээг чөлөөлөх
 - D. Зөвлөлт Орос улсын дэмжлэгийг авах ажлыг зохион байгуулах
 - E. Гамин болон цагаантны эсрэг тэмцэх, улс орноо бүрэн чөлөөлөх
42. 1921 оны хувьсгалын үр дүнд улс төрийн хүрээнд гарсан дэвшлийг сонгоно уу /1 оноо/
- A. “Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ийг батлан гаргав
 - B. 1922 оноос цэрэг, улс төрийн боловсон хүчнээ Зөвлөлт Орос улсад суралцуулж эхлэв
 - C. Бага, дунд сургуулийн танхимын дүрмийг батлаж, 1922 оноос багш бэлтгэж эхлэв
 - D. Хамжлагат ёсыг халж, бусдын хөдөлмөрийг мөлжих, бусдад зарцлагдах явдал зогсов
 - E. Өртөө улааг цэгцэлж, шуудан холбооны газар байгуулан, үндэсний мөнгөн тэмдэгттэй болох эхлэл тавигдав.
43. 1921 оны хувьсгалын үр дүнг оновчтой тодорхойлсоныг олно уу /2 оноо/
- A. Манж, Хятадын 220 жилийн дарлал унасан
 - B. Манж Чин улсаас салж тусгаар тогтнолоо сэргээсэн
 - C. Шинэ засгийн бодлогыг таслан зогсоосон
 - D. Монгол улс тусгаар тогтнолоо дахин олж сэргээсэн
 - E. Хятадын ДИУ-тай найрамдалт харилцаа тогтоосон
44. Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа хэзээ баталсан бэ? /1 оноо/
- A. 1924.VII.10
 - B. 1921.VII.10
 - C. 1924.XI.26
 - D. 1911.XII.29
 - E. 1921.VII.1-3
45. Анхдугаар Үндсэн хуулиар хэний улс төрийн эрхийг хассан бэ? /1 оноо/
- A. Жинхэнэ ардууд
 - B. Ном хурдаг лам нар
 - C. Үгээгүй ядуу ардууд
 - D. Жирийн малчид
 - E. Чинээлэг иргэд
46. БНМАУ-д 1930-аад оноос бүх нийтийг ямар бичиг үсэгт сургах ажил өрнөсөн бэ? /1 оноо/
- A. Орос бичиг
 - B. Кирилл бичиг
 - C. Монгол бичиг
 - D. Латин бичиг
 - E. Үндэсний бичиг
47. Улс төрийн хэрэгт баривчлагдагсдыг шүүн таслах эрхтэй “Онцгой бүрэн эрхт комисс” хэзээ, хэний удирдлагаар байгуулагдсан бэ? /2 оноо/
- A. 1939.X.2, А.Амар

- B. 1937.IX.10 X.Чойбалсан
- C. 1937.IV.15 А.Амар
- D. 1939.IV.15, X.Чойбалсан
- E. 1937.X.2, X.Чойбалсан

48. БНМАУ-ын ерөнхий сайд асан А.Амарын ЗХУ-ын цэргийн коллегийн шүүхийн хаалттай хуралдаанд өгсөн мэдүүлгээс:

“...Монголын тагнуул, хуйвалдааны байгууллагын удирдагчдын нэг нь гэж намайг буруутгаж байна. БНМАУ-д ямар ч хувьсгалын эсэргүү байгууллага байгаагүй...хүчинд автаж аргагүй байдалд хүрч өгсөн миний мэдүүлэг гэгчээр баригдсан улсууд бол хувьсгалын эсэргүү огт биш” гэсэн баримтад ямар үйл явдлын тухай өгүүлж байгааг тогтоон уу? /2 оноо/

- A. Улс төрийн зүтгэлтнүүдийг хилс хэрэгт гүтгэж, хэлмэгдүүлж байсан тухай
- B. Улс орны тусгаар тогтнолд аюул, занал учруулсан бүлэг этгээдүүдийг илрүүлсэн тухай
- C. ЗХУ, Монголыг хувьсгалын эсэргүү нараас хамгаалж байсан тухай
- D. БНМАУ-ын хөгжлийн чиг шугамыг эсэргүүцэгчдийг таслан шийтгэж байсан тухай
- E. Хувьсгалын эсэргүү бүлгийн удирдагчдийн өгсөн мэдүүлгийн тухай

49. Дэлхийн II дайны дараа БНМАУ-ын гадаад харилцаанд ямар томоохон дэвшил гарсан бэ? /1 оноо/

- A. Их Британи улстай соёл, боловсролын салбарт хамтран ажиллах болсон
- B. Их Британи, АНУ-аас БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох хүсэлтээ илэрхийлсэн
- C. Хятад улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэн
- D. Монгол улсын бие даасан байдлыг дэлхийн их гүрнүүд хүлээн зөвшөөрсөн
- E. Дэлхийн улс орнуудтай шинжлэх ухааны бүхий л салбарт хамтран ажиллах болсон

50. Аугаа эх орны дайнд БНМАУ хууль эрх зүйн ямар үндэслэлээр ЗХУ-ын талд тусламж үзүүлж байсан бэ? /2 оноо/

- A. 1936 оны “Үл довтлолцох гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- B. 1921 оны “Монгол-Оросын найрамдлын гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- C. 1936 оны “Харилцан туслалцах гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- D. 1939 оны “Эв найрамдлын гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- E. 1939 оны “Үл довтлолцох гэрээ”-нд заасан үүргийн дагуу

51. МоАХ /Монголын ардчилсан холбоо/ - ны анхны цуглаан хэзээ болсон бэ? /1 оноо/

- A. 1990 оны 3-р сарын 7-нд
- B. 1989 оны 12-р сарын 10-нд
- C. 1990 оны 3-р сарын 9-нд
- D. 1990 оны 3-р сарын 12-нд
- E. 1989 оны 12-р сарын 17-нд

52. “Хэлэх үгийг минь боогдуулж, харах нүдийг минь халхална” дууны шүлгийн мөрүүд нийгмийн аль үеийг төлөөлж байна? /2 оноо/

“Хонхны дуу”

*“Урт гар намайг зовооно
Хэлэх үгийг минь боогдуулж
Харах нүдийг минь халхална
Аз болж хонх дуугарлаа
Арай ядан нойрноос сэвлээ”*

- A. 1921 оны хувьсгалын өмнөх үе
- B. 1990 оны хувьсгалын өмнөх үе
- C. 1990 оны хувьсгалын дараах үе
- D. 1990 оны хувьсгалын үе
- E. 1921 оны хувьсгалын дараах үе

53. МоАХ /Монголын ардчилсан холбоо/ -ны ерөнхий зохицуулах зөвлөлийн гишүүдийн хэн нь лам байсан бэ? /1 оноо/

- A. Э.Бат-Үүл
- B. Д.Баасан
- C. Ц.Элбэгдорж
- D. С.Зориг
- E. Ж.Батмөнх

54. 1990 оны “Ардчилсан хувьсгал”-ын үр дүнд улс төрийн хүрээнд гарсан өөрчлөлт аль вэ? /2 оноо/

- A. 2015 онд хүн амын тоо 3 саяд хүрэв
- B. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө баталгаажив
- C. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжив
- D. Өмчийн бүх хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөв
- E. 1992 онд анхны чөлөөт, шударга, ардчилсан сонгууль явагдав

55. 2006 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлох үйл явдал аль нь вэ? /1 оноо/

- A. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав
- B. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав
- C. Японы ерөнхий сайд Т.Кайфу айлчлав
- D. НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав
- E. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлагдав

56. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдсанаар Энэтхэг, Япон, БНСУ, Турк зэрэг улстай харилцан хамтын ажиллагааг хөгжүүлэх нь ямар бодлого вэ? /1 оноо/

- A. Гадаад харилцааны үндсэн зорилт
- B. Монгол төрийн хар хайрцагны бодлого
- C. Гадаад харилцааны тулгуур бодлого
- D. Гадаад харилцааны үндсэн бодлого
- E. Гуравдагч хөршийн бодлого

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- a. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
- b. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Эртний улсуудын түүхэнд холбогдох соёлын дурсгалуудыг зөв харгалзуулна уу

/6 оноо/

- | | |
|-------------------------------|----------|
| a. Руни бичиг | 1.Жужан |
| b. Хар балгас | 2.Сяньби |
| c. Их бага бичиг | 3.Хүннү |
| d. Төр шашныг хослон барих ёс | 4.Түрэг |
| e. Бөө мөргөл | 5.Уйгар |
| f. Эмээлийн төмөр дөрөө | 6.Хятан |

2.2. Монголын Юань улсын түүхэнд холбогдох үйл явдлыг он цагтай нь зөв харгалзуулна уу

/6 оноо/

- | | |
|---|----------------|
| a. Юань улс унаж, Хятад дахь Монголын ноёрхол эцэс болов. | 1. 1264 он |
| b. Төвөдийн Пагва ламыг залж хоёр ёсны зарчмыг хэрэгжүүлэв | 2. 1271 он |
| c. Улсын нэрийг Да Юань буюу Их Юань хэмээн өөрчлөв | 3. 1260 он |
| d. Олон жил дараалан ган зуд нүүрлэн улсын эдийн засаг доройтов | 4. 1269 он |
| e. Хубилай хаан нийслэлээ өнөөгийн Бээжинд нүүлгэн шилжүүлэв | 5. 1300-аад он |
| f. Хубилай хаан Пагва ламаар дөрвөлжин бичгийг зохиолгов | 6. 1368 он |

2.3. 1911-1918 оны түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/

/6 оноо/

- | | |
|--|------------|
| a. Т.Намнансүрэн анхны ерөнхий сайд болов | 1. 1911 он |
| b. Үндэсний банк байгуулах эхлэл тавигдав | 2. 1912 он |
| c. “Нийслэл сонин бичиг” сэтгүүл гарав | 3. 1913 он |
| d. “Шинэ толь” сэтгүүл хэвлэгдэх болов | 4. 1914 он |
| e. Богд Жавзандамба шашин, төрийг хослон баригч хаанд өргөмжлөгдөв | 5. 1915 он |
| f. Дээд, доод танхим бүхий улсын их хурал байгуулагдав | 6. 1916 он |
| | 7. 1917 он |
| | 8. 1918 он |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг зөв тогтооно уу.

/6 оноо/

- | | |
|---|------------|
| a. Төр засаг, хэлмэгдэгсдийн үр ач нараас хэзээ уучлал гуйсан бэ? | 1. 2032 он |
| b. Монгол улсын хүн амын тоо хэдэн онд 3 саяд хүрсэн бэ? | 2. 2040 он |
| c. 1206 онд байгуулагдсан Их Монгол улсын 830 жилийн ой хэзээ болох вэ? | 3. 1996 он |
| d. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн 40 жилийн ой хэзээ болох вэ? | 4. 1991 он |

- e. 1990 оны ардчилсан хувьсгалын 50 жилийн ой хэзээ болох вэ? 5. 2015 он
- f. Монгол бичгээ сэргээж хос бичигтэн болгох ажил хэзээ өрнөсөн бэ? 6. 2036 он

№	С ХУВИЛБАР	
	Зөв хариу	Оноо
1	A	1
2	C	1
3	E	1
4	D	1
5	B	1
6	D	2
7	B	1
8	E	2
9	D	1
10	A	2
11	E	2
12	A	1
13	D	2
14	C	1
15	B	1
16	D	2
17	E	1
18	A	1
19	D	2
20	C	2
21	B	1
22	D	1
23	E	1
24	A	1
25	D	1
26	C	2
27	B	1
28	D	2
29	E	1
30	A	1
31	D	1
32	C	1
33	B	2
34	D	1
35	E	1
36	A	2
37	D	1
38	C	2
39	B	1
40	D	1

41	E	2
42	A	1
43	D	2
44	C	1
45	B	1
46	D	1
47	E	2
48	A	2
49	D	1
50	C	2
51	B	1
52	D	2
53	B	1
54	E	2
55	B	1
56	E	1
2.1	A=4, B=5, C=6, D=1, E=3, F=2	6
2.2	A=6, B=3, C=2, D=5, E=1, F=4	6
2.3	A=2, B=6, C=5, D=3, E=1, F=4	6
2.4	A=3, B=5, C=6, D=1, E=2, F=4	6